Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Дээд боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, харьяа байгууллагын статистикийн бодлого, төлөвлөлт, өгөгдлийн шинжилгээ, мэдээллийн сангийн зохицуулалт хариуцсан ахлах шинжээч, Дорж Анхзаяа

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Боловсролын салбарын их өгөгдөлд статистикийн шинжилгээ хийж, дата аналитикийн системээр дашборд хөгжүүлж, хэрэглэгчдэд хүргэж, дижитал хувилбарыг нэвтрүүлнэ. | | | | | | | |
| 1 | Боловсролын салбарын их өгөгдөлд статистикийн шинжилгээ хийж, дата аналитикийн системээр дашборд хөгжүүлж, хэрэглэгчдэд хүргэж, дижитал хувилбарыг нэвтрүүлнэ. | Дашбордын тоо | - | Боловсролын салбарын 2024-2025 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн дашборд боловсруулах бэлтгэл ажлыг хангах | Боловсролын салбарын захиргааны болон албан ёсны статистикийн мэдээллийн нэгдсэн дижитал санг үүсгэх зорилгоор 2024-2025 оны хичээлийн жилийн статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, сүүлийн 4 жилийн динамик мэдээлэл болон ирэх 4 жилийн хэтийн тооцоо, төсөөллийн шинжилгээг хийж үр дүнгээр нь сонирхолтой дүрслэл бүхий нийт 25 төрлийн "TABLEAU DASHBOARD"-ыг хөгжүүлэн хэрэглэгчдийг мэдээллээр хангасан. Үүний үр дүнд Боловсролын салбарын дижитал шилжилтийн санаачилгыг салбарын албан ёсны статистик мэдээллийн дашбордоор баяжуулан, салбарын бодлого шийдвэр, стратегийн болон өдөр тутмын шийдвэр гаргах үйл явцад өгөгдөл-мэдээллийн шинжилгээ буюу дата аналитикийг ашиглах | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боломжийг бүрдүүлж өгсөн ажил юм. Мөн энэ нь Монгол Улсын Засгийн газраас гаргасан төрийн их өгөгдөл бүрдүүлэх санаачилгыг хэрэгжүүлэх ажлын нэг хэсэг юм. Жишээ байдлаар зарим дашбордыг зураг байдлаар хавсаргав. Та дэлгэрэнгүй байдлаар бүх дашбордтой танилцахыг хүсвэл дараах 2 төрлийн линк дээр дарж үзнэ үү. Дашборд руу холбогдох линк-1: http://bi.esis.edu.mn/ Дашборд руу холбогдох линк-2: https://public.tableau.com/app/profile/ankhaa.d/vizzes<br>Хавсралт: 5 файл | | 100% |
| 1.2. Боловсролын салбарын 2024-2025 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэл боловсруулж цаасан болон цахим хэлбэрээр олон нийтэд сурталчилна. | | | | | | | |
| 2 | Боловсролын салбарын 2024-2025 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэл боловсруулж цаасан болон цахим хэлбэрээр олон нийтэд сурталчилна. | Эмхэтгэлийн тоо | Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2023-2024 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэл боловсруулан нийт 1500 ширхэгийг хэвлэж, нийтэд тархаасан. | Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2024-2025 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэл боловсруулан нийт 300 ширхэгийг хэвлэж, нийтэд тархаасан байна. | Боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэлийн эхийг бэлтгэн, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн чуулганд зориулан хэвлүүлж, бодлого боловсруулагчдыг мэдээллээр хангасан нь онцлог болсон. Боловсролын сайдын 2025 оны “Бүсчилсэн хөгжлийн чуулган зохион байгуулах тухай” тушаалын хүрээнд "Боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхэтгэл"-ийг боловсруулан хэвлүүлж, Бүсчилсэн хөгжлийн чуулганд оролцогч 7 бүсийн нийт 700 орчим төлөөлөгчид хүргүүлж, салбарын бодлого үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангасан. Эмхэтгэлийн эцсийн үр дүнгийн тайланг УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүд, бодлогын зарим яамд, яамны харьяа байгууллага, орон нутгийн боловсролын байгууллагууд болон бусад бодлого боловсруулагчид, хэрэглэгчдэд тархааж, яамны албан ёсны | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цахим хаягт байршуулан нээлттэй мэдээлэл авах боломжоор ханган ажилласан. Боловсролын салбарын статистикийн мэдээллийн 2024-2025 оны хичээлийн жилийн эмхэтгэлийн нийт 135 хуудас тайланг сүүлийн 4 жилийн динамик мэдээллээр баяжуулан боловсруулж, яамны газар хэлтсүүдээс санал авч тусган хамтран ажилласан. Тус тайланг нийт 7 бүлгийн хүрээнд 2500 орчим үзүүлэлтээр баяжуулан боловсруулсан. Бүлэг бүрд салбарын үндсэн үзүүлэлтүүдийг сүүлийн 4 жилийн динамикаар баяжуулан анализ хийж, өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэн дүн шинжилгээ хийж, цаашдын төлөв байдлыг 2030 он хүртэлх динамикаар тооцоолсон үр дүнг тайланд тусгасан. 2024-2025 оны хичээлийн жилийн боловсролын салбарын статистикийн эмхэтгэлийг боловсруулахдаа хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар мэдээллийг хүргэх зорилгоор инфографикаар дүрсэлсэн. Энэ хичээлийн жилд боловсролын салбарын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтүүд, салбарын статистик мэдээллийг анх удаа дижитал хувилбараар ухаалаг дашборд дээр хөгжүүлэн эмхэтгэлийн нүүр хуудаст QR кодтойгоор оруулж өгснөөрөө онцлог болсон.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.3. Боловсролын салбарын 2025-2026 оны хичээлийн жилийн статистик мэдээллийг нэгтгэх, тайлагнах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангана. | | | | | | | |
| 3 | Боловсролын салбарын 2025-2026 оны хичээлийн жилийн | Албан ёсны статистикийн мэдээний | Боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн албан | - | Боловсрол, шинжлэх ухааны сайд болон Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны “Маягт шинэчлэн батлах тухай” А/313 дугаар тушаалаар батлагдсан захиргааны статистикийн нийт 16 маягтаар боловсрол | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | статистик мэдээллийг нэгтгэх, тайлагнах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангана. | тоо | ёсны статистикийн мэдээллийг батлагдсан маягт, аргачлалын дагуу нэгтгэн, хянаж, боловсруулан үр дүнг батлагдсан хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэх бэлтгэл ажлыг хангах | | сургалтын нийт байгууллагуудын 2024 оны төсвийн зардлын гүйцэтгэл, хөрөнгийн жилийн эцсийн мэдээг нэгтгэн цуглуулж хянаад 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 3/1165 тоот албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн. Мэдээг хүргүүлсний дараа ҮСХ-оос мэдээнд хяналт хийгдсэн ба боловсролын салбарын бүтээгдэхүүний тооцоо хийхэд ашигласан. ҮСХ-оос ирүүлсэн хүсэлтийн дагуу сургуулийн өмнөх боловсролын 1410, ерөнхий боловсролын 871, мэргэжлийн болон техникийн боловсролын 76, дээд боловсролын 65 сургалтын байгууллагын 2024 оны төсвийн зардлын гүйцэтгэл, хөрөнгийн жилийн эцсийн мэдээний нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээний өсөлт, бууралтын шалтгаан тайлбар, нэмэлт тодруулга авах ажлыг зохион байгуулж, нийт 102 байгууллагаас тодруулга авч, ҮСХ-д хүргүүлэн боловсролын салбарын бүтээгдэхүүний тооцоо хийх ажилд оролцож хамтран ажилласан.<br>Хавсралт: 4 файл | 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 4 | Боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн төгсөгчдийн статистик мэдээллийг нэгтгэх, тайлагнах үйл ажиллагааг удирдлага, зохион | Албан ёсны статистикийн мэдээний тоо | Боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн албан ёсны статистикийн мэдээллийг батлагдсан маягт, аргачлалын дагуу нэгтгэн, хянаж, | - | 2024-2025 оны хичээлийн жилийн дэвшилт, төгсөлт, улсын шалгалтын дүнг БСМС системд оруулах, мөн суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшиж буй 103,050 суралцагчид боловсролын баримт бичиг олгох үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох мэдээллийг 700 гаруй ерөнхий боловсролын сургуульд хүргэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан. Боловсрол, шинжлэх ухааны сайд болон Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны “Маягт шинэчлэн батлах тухай” А/313 дугаар тушаалаар батлагдсан | 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллалтаар хангана. ЕБС, МБТБ, ДБ-ын салбарын төгсөлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хэрэглэгчдэд зориулсан дашборд хөгжүүлж, мэдээллээр хангана. | | боловсруулан үр дүнг батлагдсан хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэх бэлтгэл ажлыг хангах | | албан ёсны статистикийн мэдээний 22 маягтаар боловсрол сургалтын байгууллагыг нийт төгсөгчдийн статистикийн мэдээг нэгтгэн цуглуулж хянаж байна. Төгсөгчдийн мэдээний тайланг батлагдсан хугацаа болох 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор эцсийн байдлаар албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Дэвшилт төгсөлтийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.<br>Хавсралт: 8 файл | | төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 1.4. Боловсролын салбарын статистикийн мэдээ, мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах | | | | | | | |
| 5 | Боловсролын салбарын статистикийн мэдээ, мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах | Сургалтад хамрагдсан хүний тоо | Боловсролын салбарын статистикийн мэдээ, өгөгдлийн сангийн зохицуулалт хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. | Боловсролын салбарын статистикийн мэдээ, өгөгдлийн сангийн зохицуулалт хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх | 2024-2025 оны хичээлийн жилийн дэвшилт, төгсөлт, дүн үнэлгээ, хүүхэд хамгаалал, оролцооны албан ёсны статистикийн мэдээ 2025 оны 6 дугаар сарын 30-ны дотор шинэчилсэн маягтын дагуу нэгжээс цуглуулагдан хянагдаж, улсын хэмжээнд нэгтгэгдэж, 2025 оны 7 сарын 25-нд яаманд ирэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2024-2025 оны хичээлийн жилийн төгсөгч, дүн үнэлгээний мэдээллийг батлагдсан маягт, аргачлалын дагуу нэгтгэн, хянаж, боловсруулан үр дүнг нэгтгэн гаргах чиглэлээр 2025 оны 03 сараас эхлэн нийт 4 удаагийн цахим чиглүүлэх сургалтыг орон нутгийн боловсролын байгууллагын нийт 80 гаруй албан хаагчдад цахимаар хийж мэдээлэл өгч, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан. Боловсролын салбарын статистикийн мэдээ, мэдээллийн систем хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах чиглэлээр дараах байдлаар ажилласан. МБТБ, Дээд боловсролын 2024-2025 оны | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хичээлийн жилийн төгсөгчдийн албан ёсны статистикийн мэдээний бэлтгэл ажлыг хангахтай холбоотойгоор БШУ-ны сайдын 2024 оны А/143 тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын төсгөлтийн журам”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой системээр төгсөлт хийх, лавлагааны санд оруулах алхамчилсан зөвлөмжийг БМТТ, БЕГ болон дээд боловсролын сургалтын байгууллагуудад хүргүүлж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. СӨБ-ын дэвшилт, төгсөлтийн бүртгэлийг 2024 оны 05 сарын 20-ны өдрөөс системд нээж аймаг дүүргийн мэргэжилтнүүдэд чиглүүлэх сургалтыг цахимаар хийж, мэдээлэл хүргэн ажиллаж байгаа цэцэрлэгийн дэвшилт, төгсөлтийн бүртгэл 100 хувь хийгдсэн. ЕБС-ийн төгсөлтийн мэдээний шинэчилсэн маягтын хөгжүүлэлтийг туршиж, нэгжид гаргасан. Үүний дагуу Нийслэл болон аймгуудад нэгдсэн зааварчилгаа чиглэл хүргүүлэх албан мэйл явуулсан ба аймаг, нийслэлийн БШУГ-ууд болон ЕБС-иудаас системд улсын шалгалт болон анги дэвших шалгалтын дүн шивэх эрх нээхтэй холбогдон нэгжийн түвшинд ачаалал үүсгэхгүй байхад анхаарах тухай арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. | | |
| 1.5. Боловсролын салбарын мэдээллийн системийн баяжуулалт, лавлагааны сангийн бүрдүүлэлт хийнэ. | | | | | | | |
| 6 | Боловсролын салбарын мэдээллийн системийн баяжуулалт, лавлагааны | Мэдээллийн сангийн баяжуулалт, лавлагаа нөхөн бүрдүүлэлт | 2024-2025 оны хичээлийн жилд Дээд боловсролын сургалтын байгууллагад | Бүрэн дунд боловсролын үнэмлэхийн тодорхойлолт, Ерөнхий боловсролын | 2025 оны 06 сарын байдлаар 2024-2025 оны хичээлийн жилд Дээд боловсролын сургалтын 65 байгууллагад суралцаж буй 150,282, ЕБС-д суралцаж буй 797,905, СӨБ суралцаж буй 264,818, НТБТ-д суралцаж буй 4,422 иргэний мэдээллээр лавлагааны | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, | Өөрийн үнэлгээ: 100%<br><br>Нэгжийн даргын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сангийн бүрдүүлэлт хийнэ. | | суралцаж буй 150,282, ЕБС-д суралцаж буй 797,905, СӨБ суралцаж буй 264,818, НТБТ-д суралцаж буй 4,422 иргэний мэдээллээр лавлагааны сангийн баяжилтыг хийсэн ба 460,909 иргэний дээд боловсролын баримт бичиг баталгаажиж E-Mongolia системийн санд орсон байна. | сургуулийн Улсын шалгалтын нэгдсэн дүнгийн хуулбар, Суурь боловсролын гэрчилгээний тодорхойлолт, Элсэлтийн ерөнхий шалгалтын лавлагаа, шалгуулагчийн мэдээлэл, Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, Нийслэлийн цэцэрлэгт хамрагдах хүсэлтийн үр дүнгийн лавлагаа, тодорхойлолтыг Төрийн үйлчилгээний цахим мэдээллийн И-Монголиа системээс авах үйлчилгээг нэвтрүүлэх | сангийн баяжилтыг хийсэн ба 472,238 иргэний дээд боловсролын баримт бичиг баталгаажиж E-Mongolia системийн санд орсон байна. | 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | үнэлгээ: 100%<br><br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.6. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарын шалгуур үзүүлэлтийг тооцох, үр дүнг хугацаанд нь тайлагнах | | | | | | | |
| 7 | Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарын шалгуур үзүүлэлтийг тооцох, үр дүнг хугацаанд нь тайлагнах | Үр дүнг тооцсон бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн тоо | Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарын шалгуур үзүүлэлтийг 2023-2024 оны хичээлийн жилийн статистикийн мэдээнд үндэслэн тооцож, үр дүнг хугацаанд нь тайлагнасан. | Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарын шалгуур үзүүлэлтийг 2024-2025 оны хичээлийн жилийн статистикийн мэдээнд үндэслэн тооцох, үр дүнг хугацаанд нь тайлагнах | Монгол Улсын хөгжлийн бодлогын урт хугацааны баримт бичиг болох “Алсын хараа-2050” бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлт болон Тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг 2024-2025 оны хичээлийн жилийн байдлаар тооцож, нийт 18 үзүүлэлтийн хүрээнд үр дүнг 2025 оны 04 сарын 30-ны өдрийн 1/1788 тоот албан бичгээр ҮСХ-д хүргүүлсэн. ҮСХ-ноос ирүүлсэн хүсэлтийн дагуу Аж ахуйн нэгжийн тооллогод ашиглах боловсролын салбарын суурь болон төрөлжсөн захиргааны статистикийн мэдээллийн сангийн бэлэн байдлын үнэлгээний мэдээллийг бэлтгэн ҮСХ-д цахимаар хүргүүлсэн. ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнгээс гаргасан нийт 34 маягтын дагуу боловсролын салбарын 2024-2025 оны статистик тоон мэдээллийг нийт 850 орчим үзүүлэлтийн хүрээнд нэгтгэн, тайланг хүргүүлээд байна. Тайланг хянаж ажил хийгдэж байна.<br>Хавсралт: 2 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 3.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | | | | | | | |
| 8 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, | Төлөвлөгөө, тайлангийн тоо | Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилт арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, Удирдлагаас | Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилт арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, Удирдлагаас | 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 8 зорилтын 9 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилд удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу нийт 3 ажлын хэсэгт орж ажилласан. Удирдлагаас өгсөн цаг үеийн 18 удаагийн шуурхай үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж, үр дүнг тайлагнасан. Боловсролын статистик мэдээллийн хэлтсийн дотоод | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | | өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, Байгууллагын шуурхай, хурал, цуглаан, мэдээллийн цагт оролцсон байна. | өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, Байгууллагын шуурхай, хурал, цуглаан, мэдээллийн цагт оролцсон байна. | асуудлыг хариуцан ажиллаж, бусад албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, БНБТГ болон яамны 2025 оны үйл ажиллагааны зорилт арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үйл явцад хамтран оролцож, сар бүрийн тайланг боловсруулан хянуулж, удирдлагыг шуурхай мэдээллээр хангаж ажилласан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс гадна газрын даргын өгсөн цаг үеийн шуурхай үүрэг даалгаврыг цаг тухай бүрд нь биелүүлж, яамны шуурхай, хурал, цуглаанд идэвхтэй оролцож, яамнаас зохион байгуулсан сургалт бүхий мэдээллийн цагт тогтмол оролцож, мэдээлэл авсан. Нийт тайлангийн тоо:• Сарын тайлан: 2025 оны эхний хагас жилд нийт 6 удаагийн сарын тайланг боловсруулан, газрын даргаар баталгаажуулсан. • Хагас болон бүтэн жилийн тайлан: 2025 оны эхний хагас жилийн тайланг боловсруулан нэгтгэж, удирдлагад хүргүүлсэн. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 3 ажлын хэсэгт ажиллаж байна. Ажлын хэсгийн тушаалуудыг хавсаргав. 2025 оны эхний хагас жилд нийт 17 албан бичиг 3 өргөдөл хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүлсэн. Эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн чиглэлийг шинэчлэх: Энэ ажлын хүрээнд эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн 2030 он хүртэлх хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг хийж ажлын хэсгийг мэдээллээр хангаж ажилласан. Мөн нэгтгэсэн судалгааны мэдээллээр дашборд боловсруулан удирдлага болон ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн. ТАЗ, БЯ-ны хамтарсан ажлын хэсэг: Төрийн албан хаагчдын дээд боловсрол эзэмшсэн боловсролын баримт бичгийн мэдээллийг системд оруулах, мэдээллийн санг баяжуулах, бүрдүүлэх ажлыг зохион | 10-р сар, 11-р сар, 12-р сар | Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулахад хамтран ажилласан. Мөн “Боловсролын төлөөх даян дэлхийн түншлэл” (GPE) төслийн ажлын хэсэгт ажиллаж байна.<br>Хавсралт: 8 файл | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Боловсролын салбарын статистикийн чиглэлээрх Гадаад, дотоод сургалтад хамрагдах | Боловсролын салбарын статистикийн чиглэлээрх Гадаад, дотоод сургалтад хамрагдах | - | Боловсролын салбарын хөгжлийн чиглэлээр мэдлэг, чадвараа дээшлүүлж, чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдсан байна. | МУИС-иас зохион байгуулсан сургалт болох POWER BI & EXCEL ашиглан бодит тоон өгөгдөл дээр дата анализ хийж сурах “DATA ANALYSIS – ПРАКТИК” сургалтад хамрагдсан. Тус сургалтад хамрагдсанаар өгөгдөлд суурилсан аналитик шийдэлд суралцаж, дата өгөгдлийг боловсруулах, их өгөгдөлд дүн шинжилгээ хийж, оновчтой шийдвэр гаргалтад зориулсан ухаалаг хяналтын самбар-дашборд хөгжүүлэх ур чадварыг AI, POWER BI, TABLEAU программ дээр эзэмшсэн. Энэхүү сургалтад хамрагдсанаар боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн захиргааны статистик мэдээллийг бодлого боловсруулагчдад зориулан анх удаа дижитал хувилбараар ухаалаг дашборд дээр хөгжүүлэн нийтэлж, "Боловсролын салбарын статистикийн мэдээллийн эмхэтгэл-2025"- | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ийн нүүр хуудаст QR кодоор кодлон оруулж өгсөн нь шинэлэг ажил болсон. Хөгжүүлсэн дашбордтой танилцахыг хүсвэл дараах 2 төрлийн линк дээр дарж үзнэ үү. Дашборд руу холбогдох линк-1: http://bi.esis.edu.mn/ Дашборд руу холбогдох линк-2: https://public.tableau.com/app/profile/ankhaa.d/vizzes | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Дээд боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, харьяа байгууллагын статистикийн бодлого, төлөвлөлт, өгөгдлийн шинжилгээ, мэдээллийн сангийн зохицуулалт хариуцсан ахлах шинжээч, Дорж Анхзаяа /................................................../
Огноо: .........................